



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2016 оны 01 сарын 15 өдөр

Дугаар A-20

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Төлбөрийн системд мөрдөх мэдээллийн технологийн тасралтгүй, найдвартай ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.“Төлбөрийн системд мөрдөх мэдээллийн технологийн тасралтгүй, найдвартай ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллахыг Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан), банкуудын гүйцэтгэх захирал нарт тус тус даалгасугай.

3.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан)-т үүрэг болгосугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А-40 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ



ТӨЛБӨРИЙН СИСТЕМД МӨРДӨХ МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ТАСРАЛТГҮЙ, НАЙДВАРТАЙ
АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь мэдээллийн технологийн үйл ажиллагаа доголдсоны улмаас төлбөр тооцоо саатах, системийн эрсдэл үүсгэх нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэхийн тулд төлбөрийн системийн оператор, оролцогчийн үйл ажиллагаандаа дагаж мөрдвөл зохих шаардлагуудыг тодорхойлох, түүнд хяналт тавихад оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Энэхүү журмыг их, бага дүнтэй төлбөр тооцооны систем, картын нэгдсэн сүлжээ болон санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн үйл ажиллагаатай холбоотой төлбөр тооцооны систем, төлбөрийн системд нөлөө үзүүлж болзошгүй гэж үзсэн бусад төлбөр тооцооны системийн оператор, оролцогч дагаж мөрдөнө.

2.1.1. Төлбөрийн системийн оролцогч (цаашид “оролцогч” гэх) гэдэгт банк, Сангийн яамны Төрийн сангийн газар, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв, Хөгжлийн банк хамаарна.

2.1.2. Төлбөрийн системийн оператор (цаашид “оператор” гэх) гэдэгт банк хоорондын их дүнтэй төлбөр тооцооны “Банксүлжээ” системийг хариуцан ажиллаж буй Төлбөрийн бодлого, зохицуулалтын хэлтэс, бага дүнтэй болон картын төлбөр тооцооны системийг хариуцан ажиллаж буй Үндэсний цахим гүйлгээний төв хамаарна.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Энэ журамд дурдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно:

- 3.1. “Үндсэн төв” (main site) гэж төлбөрийн системийн оператор, оролцогчийн ашиглаж буй мэдээллийн технологийн үндсэн систем, түүний техник төхөөрөмжийн байгаа байршлыг;
- 3.2. “Нөөц төв” (backup site) гэж үндсэн төвд онцгой байдал үүсэх үед төлбөр тооцооны тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор байгуулсан, мэдээллийн технологийн нөөц систем, түүний техник төхөөрөмжийн байгаа байршлыг;
- 3.3. “Онцгой байдал” гэж техник, програм хангамжийн алдаа, хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл, гал түймэр, газар хөдлөлт, хүчтэй салхи, үер, аянга зэрэг гэнэтийн осол, байгалийн гамшиг болон бусад шалтгаанаар мэдээллийн технологийн системийн хэвийн үйл ажиллагаа 2 (хоёр) цагаас дээш хугацаагаар алдагдахыг;
- 3.4. “Төлөвлөгөөт зогсолт” гэж засвар, үйлчилгээ хийх зорилгоор оператор, оролцогчдод урьдчилан мэдэгдэж системийн үйл ажиллагааг хэсэгчлэн болон бүрэн зогсоохыг;

3.5. “Гэнэтийн саатал” гэж тухайн системийн үйл ажиллагаа 2 (хоёр) минутаас дээш хугацаагаар, төлөвлөгөөт бусаар хэсэгчлэн болон бүрэн зогсохыг.

4. ЖУРАМ, ЗААВАР

4.1. Оператор болон оролцогч нь өөрийн мэдээллийн технологийн үйл ажиллагааг зохицуулсан журам, дүрэм, заавар, гарын авлагатай байна. Дараах үйл ажиллагаа, стандартыг журмаар зохицуулна:

4.1.1. Үндсэн төвийн үйл ажиллагаа, стандарт;

4.1.2. Нөөц төвийн үйл ажиллагаа, стандарт;

4.1.3. Мэдээллийн сангийн үйл ажиллагаа, түүнийг нөөцлөх талаар.

4.2. Мэдээллийн технологийн үндсэн болон нөөц төв, түүний систем, програм хангамж, тоног төхөөрөмжид том хэмжээний өөрчлөлт оруулсан эсвэл ноцтой гэмтэл гарсан бол шаардлагатай тохиолдолд оператор, оролцогч нь өөрийн журам, зааварт өөрчлөлт оруулна.

5. ТАСРАЛТГҮЙ, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГАА

5.1. Үндсэн төвийн тасралтгүй, найдвартай ажиллагаанд дараах шаардлагыг тавина. Үүнд:

5.1.1. Үндсэн төвийн техник, програм хангамжийн засвар, үйлчилгээ, шинэчлэлийг тогтмол хийх;

5.1.2. Үндсэн төвийн техник, програм хангамжийн тохиргоо, түүнд орсон өөрчлөлт бүрийг баримтжуулж, хадгалах;

5.1.3. Үндсэн төвд зөвхөн эрх бүхий хүмүүс нэвтрэх бөгөөд зайнаас хандах болон шууд нэвтрэх бүрт бүртгэл (log) хөтлөх;

5.1.4. Үндсэн төв нь цахилгааны нэмэлт эх үүсвэр болох тог баригч (UPS), эрчим хүчний нэмэлт шугам, дизел генератортой байх;

5.1.5. Үндсэн төвийн сервер, сүлжээний тоног төхөөрөмж, хөргөлтийн систем, агаарын чийгшил тохируулагч систем, гал унтраах систем, серверийн өрөөний мэдрэгчийг цахилгааны нэмэлт эх үүсвэрт холбосон байх;

5.1.6. Оролцогчийн үндсэн төвийг операторын нөөц төвтэй үндсэн ба нөөц шугамаар шууд холбосон байх.

5.2. Нөөц төвийн тасралтгүй, найдвартай ажиллагаанд дараах шаардлагыг тавина. Үүнд:

5.2.1. Нөөц төв нь шаардлагатай үед үндсэн төвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх боломжтой хангалттай хүчин чадал, тоног төхөөрөмж, програм хангамж, боловсон хүчинтэй байх;

5.2.2. Нөөц төвийг үндсэн төв байрлаж байгаа газраас хол, газар зүйн алслагдмал байршилд байгуулах;

5.2.3. Нөөц төвд зөвхөн эрх бүхий хүмүүс нэвтрэх бөгөөд зайнаас хандах болон шууд нэвтрэх бүрт бүртгэл (log) хөтлөх;

- 5.2.4. Төлөвлөгөөт зогсолт болон гэнэтийн саатал нь 2 (хоёр) цаг болон түүнээс дээш хугацаанд үргэлжлэх тохиолдолд оролцогч өөрийн мэдээллийн технологийн үйл ажиллагааг нөөц төвдөө шилжүүлэх арга хэмжээ авч, энэ талаар операторт нэн даруй мэдэгдэх;
 - 5.2.5. Нөөц төвийн техник, програм хангамжийн засвар, үйлчилгээ, шинэчлэлийг тогтмол хийх;
 - 5.2.6. Нөөц төвийн техник, програм хангамжийн тохиргоог баримтжуулж, хадгалах;
 - 5.2.7. Нөөц төв нь цахилгааны нэмэлт эх үүсвэр болох тог баригч (UPS), эрчим хүчний нэмэлт шугам, дизел генератортой байх;
 - 5.2.8. Нөөц төвийн сервер, сүлжээний тоног төхөөрөмж, хөргөлтийн систем, агаарын чийгшил тохируулагч систем, гал унтраах систем, серверийн өрөөний мэдрэгчийг цахилгааны нэмэлт эх үүсвэрт холбосон байх;
 - 5.2.9. Нөөц төвийг үндсэн төвтэй сүлжээний үндсэн ба нөөц шугамаар холбосон байх;
 - 5.2.10. Оролцогчийн нөөц төвийг оператортой үндсэн ба нөөц шугамаар шууд холбосон байх.
- 5.3. Мэдээллийн сангийн тасралтгүй найдвартай ажиллагаанд дараах шаардлагыг тавина. Үүнд:
 - 5.3.1. Мэдээллийн санг бодит цагийн (online) болон бодит бус цагийн (offline) горимд хуулбарлаж хадгалдаг байх ба энэ ажиллагааг журамд тодорхой тусгах;
 - 5.3.2. Бодит бус цагийн горимд хуулбарлаж буй мэдээллийн санг 24 (хорин дөрвөн) цаг тутамд 1 (нэг)-ээс доошгүй удаа шинэчлэх.
 - 5.4. Онцгой байдлын төлөвлөгөө, туршилтад дараах шаардлагыг тавина. Үүнд:
 - 5.4.1. Оролцогч, оператор нь системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах төлөвлөгөөтэй байх ба үүнд үйлчилгээ тасалдах, том хэмжээний осол, гэмтэл гарах үед нэн чухал үйл ажиллагааг цаг алдалгүй сэргээх үйл явцыг тодорхой тусгах;
 - 5.4.2. Тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөнд гадны болон дотоод халдлагын хүчин зүйлсийг заавал тусгах;
 - 5.4.3. Оператор нь өөрийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг жилд 1 (нэг) болон түүнээс дээш удаа бүх оролцогчдыг хамруулан туршиж, шаардлагатай өөрчлөлтийг тухай бүрт нь оруулж ажиллах;
 - 5.4.4. Оролцогч нь өөрийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг жилд 1 (нэг) болон түүнээс дээш удаа турших. Уг туршилт нь том хэмжээний осол, гэмтлийн үед үндсэн болон нөөц төвийн үйл ажиллагааг шилжүүлэх, үндсэн сүлжээний шугам тасарсан үед нөөц сүлжээг ашиглах, операторын үндсэн төв тасарсан тохиолдолд нөөц төврүү шилжих тохиолдлыг авч үзсэн байх шаардлагатай.

5.5. Төлөвлөгөөт зогсолт

- 5.5.1. Оролцогч нь операторт 1 (нэг)-ээс доошгүй цагийн өмнө урьдчилан мэдэгдсэнээр долоо хоногт нэг удаа 20 (хорин) минут хүртэлх хугацаатай төлөвлөгөөт зогсолт хийж болно;
- 5.5.2. Төлөвлөгөөт зогсолтыг 20 (хорин) минутаас дээш хугацаатай үргэлжлүүлэх бол ажлын 3 (гурав)-аас доошгүй хоногийн өмнө операторт мэдэгдэнэ. Төлөвлөгөөт зогсолт хийх тохиромжтой хугацаа нь пүрэв, ням гаргийн шөнийн 01 цагаас 06 цагийн хооронд байна;
- 5.5.3. Төлөвлөгөөт зогсолтын нийт хугацаа долоо хоногт 2 (хоёр) цагаас илүүгүй байна. Хэрэв 2 (хоёр) цагаас дээш хугацаанд төлөвлөгөөт зогсолт хийх бол үйл ажиллагааг нөөц төв рүү шилжүүлж ажиллана.

5.6. Гэнэтийн саатал

- 5.6.1. Оператор, оролцогч нь Монголбанкнаас тогтоосон тасралтгүй ажиллагааны үзүүлэлтийг хангаж ажиллана;
- 5.6.2. Оролцогч нь гэнэтийн саатлын үед түүнийг бүртгэх, мэдэгдэх, дүн шинжилгээ хийх, шийдвэрлэх журамтай байна;
- 5.6.3. Операторын системд гэнэтийн саатал гарсан тохиолдолд саатлын талаар системийн оролцогчдод нэн даруй мэдэгдэж, засварлах хугацаа, авах арга хэмжээний талаар мэдээлэл өгнө;
- 5.6.4. Оператор нь гэнэтийн саатлыг арилгаж, хариуцан ажиллуулж буй төлбөр тооцооны системийг хэвийн байдалд оруулах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлнэ. Шаардлагатай тохиолдолд оролцогчтой хамтран ажиллана.

6. НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- 6.1. Оролцогч нь орчны хамгаалалт (physical security), байгаль орчны болон мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг зохицуулсан цогц журамтай байна. Энэ журмаар дараах зүйлсийг зохицуулна:
 - 6.1.1. Үндсэн төв дэх сервер болон серверийн өрөөний аюулгүй байдлыг хэрхэн хангах;
 - 6.1.2. Нөөц төв дэх сервер болон серверийн өрөөний аюулгүй байдлыг хэрхэн хангах;
 - 6.1.3. Мэдээллийн сан дахь харилцагчийн мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хэрхэн хангах, хандалтын удирдлага, нэвтрэх эрхийн хязгаарлалттай байх;
 - 6.1.4. Сүлжээний аюулгүй байдлыг болон сүлжээгээр мэдээлэл дамжих явцад нууцлалыг хэрхэн хангах тухай.
- 6.2. Төлбөр тооцоог илгээхээс өмнөх болон хүлээн авснаас хойших аюулгүй байдал, нууцлалыг оператор, оролцогч нь бүрэн хариуцна.
- 6.3. Оператор болон оролцогч нь төлбөр тооцооны системээр дамжин хийгдэж байгаа төлбөрийн мэдээ, гүйлгээний цахим мэдээг чанд нууцална.

- 6.4. Мэдээллийн технологийн үйл ажиллагааг гуравдагч этгээдээр хэсэгчлэн эсвэл бүтнээр нь гүйцэтгүүлдэг бол оролцогч нь тухайн этгээдэд шалгуур үзүүлэлт тавьж, хянадаг байх, шаардлагатай мэдээлэлд цаг алдалгүй хандах боломжтой байх ёстой.
- 6.5. Оператор болон оролцогч нь өөрийн төлбөр тооцооны системийн техник, програм хангамж нийлүүлэгч байгууллага, ажилтан, холбогдох бусад хувь хүмүүст төлбөр тооцооны системийн аюулгүй, найдвартай, тасралтгүй байдалд сөргөөр нөлөөлж болохуйц мэдээллийг задруулахгүй байх үүрэг хүлээлгэнэ.
- 6.6. Нөөц төвийн байршлын талаарх мэдээллийг нууцлалын зэрэгт хамруулна.

7. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН СИСТЕМИЙН ӨӨРЧЛӨЛТ, ХЯНАЛТ

- 7.1. Оролцогч нь операторын эсвэл бусад оролцогчийн, хэвийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц өөрчлөлтийг өөрийн системд хийх тохиолдолд ажлын 3 (гурав)-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэнээр хамтарсан туршилт хийнэ.
- 7.2. Төлбөрийн системд ашиглагдах тоног төхөөрөмж, програм хангамж, журам, горим, хяналт зэрэгт өөрчлөлт орсноос үүдэн гарах эрсдэлийг бууруулахын тулд өөрчлөлтийн удирдлагын системтэй байна.
- 7.3. Оператор нь хариуцан ажиллуулж буй төлбөр тооцооны системд өөрчлөлт оруулахаас ажлын 15 (арван тав) болон түүнээс доошгүй өдрийн өмнө системийн өөрчлөлтийн талаарх албан ёсны мэдэгдэл, холбогдох зааврыг оролцогчид хүргүүлнэ.
- 7.4. Оператор нь оролцогч хоорондын төлбөр тооцооны системд оруулах өөрчлөлтийг хэрэгжүүлэхээс өмнө оролцогчтой хамтран туршиж, хяналт тавина. Шаардлагатай гэж үзвэл туршилтын явцад операторын зүгээс туслалцаа үзүүлнэ.

8. БУСАД

- 8.1. Төлбөр тооцооны системд саатал, гэмтэл гарах үед мэдээлэл солилцох зорилгоор мэдээллийн технологи болон төлбөр тооцоо хариуцсан албан тушаалтан, тэдгээрийг орлох албан тушаалтны нэрсийн жагсаалт, холбоо барих утас зэрэг мэдээллийг оролцогч бүр Монголбанкинд албан ёсоор хүргүүлж, нэрсийн жагсаалтад өөрчлөлт орох бүрт мэдэгдэнэ.
- 8.2. Оролцогч нь өөрийн мэдээллийн технологийн системийн бүрэн хүчин чадал, үзүүлэлтийг тогтмол хянаж, ачаалал даах чадварын туршилтыг тогтмол хийж, үнэлнэ.

9. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

- 9.1. Операторын мэдээллийн технологийн системд том хэмжээний өөрчлөлт хийгдэх, оролцогчдыг хамарсан туршилт хийх, гэнэтийн гэмтэл, саатал гэх мэт төлбөрийн системд нөлөөлж болохуйц ажиллагааны явцад Монголбанкны хянан шалгагч хяналт тавина.
- 9.2. Энэхүү журмын биелэлттэй холбоотой хяналт шалгалтыг Монголбанкны хянан шалгагч хийж гүйцэтгэнэ.
- 9.3. Энэхүү журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Монголбанкны Улсын байцаагч бүрэн эрхийнхээ хүрээнд арга хэмжээ авч, зохих хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.